

АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2023 ОНЫ 3 ДУГААР  
УЛИРЛЫН БАЙДЛААР ГАРСАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ТҮҮНИЙ ТАМГЫН  
ГАЗАРТ ДААЛГАСАН ЗААЛТ БҮХИЙ ТОГТООЛЫН ХЭРЭГЖИЛТЭД  
ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2023.10.13

Алтай хот

**Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго:** Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 3 дугаар улирлын байдлаар гарсан аймгийн Засаг дарга, түүний Тамгын газарт даалгасан заалт бүхий тогтоолын хэрэгжилтийг тодорхойлох, үр дүнд суурилсан үнэлгээ хийж, хэрэгжилтийг зохион байгуулж байгаа болон шийдвэр гаргах түвшний албан тушаалтнуудыг бодит мэдээллээр хангах, арга зүйн дэмжлэг үзүүлэхэд чиглэгдлээ.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг Төрийн захиргааны удирдлагын хэлтсээс нэгтгэн ирүүлсэн тогтоолын биелэлтэд үндэслэн гүйцэтгэлээ.

**Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн:** Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 3 дугаар улирлын байдлаар гарсан аймгийн Засаг дарга, түүний Тамгын газарт даалгасан заалт бүхий тогтоолын биелэлтийн товчоог танилцуулбал:

|                                      |              |
|--------------------------------------|--------------|
| Хяналтад авсан тогтоолын тоо         | 41           |
| Бүрэн хэрэгжсэн /100 %/              | 20           |
| Хэрэгжих шатанд /70 %/               | 11           |
| Хэрэгжилт хангалтгүй /30 %/          | 2            |
| Хэрэгжээгүй / 0 %/                   | -            |
| Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй | 8            |
| <b>БИЕЛЭЛТИЙН ДҮН /ХУВЬ/</b>         | <b>85.75</b> |

“Хэрэгжилт хангалтгүй” 2 тогтоолын шалтгаан:

| № | Огноо,<br>дугаар                    | Тогтоолын товч утга                                                                                                                                                                                                                                                                                                                                         | Шалтгаан, тайлбар                                                                                                                                                                                                                                                                     |
|---|-------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| 1 | 2023.05.29<br>Дугаар 20             | 1.Дарив сумын “Дарив Эрчим хүч” ААТҮГ, Эрдэнэ сумын “Эрдэнэ эрчим хүч” ААТҮГ-уудыг өмчлөгчийн эрх шилжсэн өдрөөр тасалбар болгон татан буулгасугай.<br>3.Татан буугдаж буй дээрх байгууллагын дуусгалтын балансыг гаргуулж, өр авлагыг барагдуулан дүгнэлтийн хамт 2023 оны 06 дугаар сард багтаан иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Зөвлөлд танилцуулж ажиллах | Тус тогтоолын дагуу орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газруудыг татан буулгах комисс 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдөр хуралдсан бөгөөд тус үйлдвэрийн газрууд нь өр төлбөрийн үлдэгдэлтэй тул дуусгалтын балансыг гаргаж, дүнг тайлагнах боломжгүй хулээгдэж байна. |
| 2 | Газар<br>нутгийг<br>орон<br>нутгийн | 1.Алтай, Бугат, Хонин усны говь орчмын 20.000 га талбайг Говь-Алтай аймгийн эрчим хүчний шинэ эх үүсвэр                                                                                                                                                                                                                                                     | Алтай, Бугат, Хонин усны говь орчмын 20.000 га талбайг эрчим хүчний шинэ эх үүсвэр байгуулах зорилгоор орон                                                                                                                                                                           |

|  |                                                         |                                                                                                                                                                                                                                         |                                                                                                                                         |
|--|---------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
|  | тусгай хэрэгцээнд авах тухай<br>2023.06.30<br>Дугаар 33 | байгуулах зорилгоор 20 жилийн хугацаатай орон нутгийн тусгай хэрэгцээнд авсугай.<br>3.Тусгай хэрэгцээнд авсан газар нутгийг Ашигт малтмал, газрын тосны газрын Кадастрын бүртгэлийн системд бүртгүүлж, хуулийн хугацаанд баталгаажуулах | нутгийн тусгай хэрэгцээнд авч Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газрын Кадастрын бүртгэлийн системд бүртгүүлэхээр бэлтгэж байна. |
|--|---------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|

## ДҮГНЭЛТ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 3 дугаар улирлын байдлаар гарсан аймгийн Засаг дарга, түүний Тамгын газарт даалгасан заалт бүхий тогтоолын биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дараах дүгнэлтийг гаргаж байна.

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 3 дугаар улиралд гарсан аймгийн Засаг дарга, түүний Тамгын газарт даалгасан заалт бүхий 41 тогтоолын 20 нь 100 %, 11 нь 70 %, 2 нь 30 %, 8 нь хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй үнэлэгдэж, 85.75 хувийн хэрэгжилттэй байна.

2.Нийт 20 тогтоол буюу 48.7 хувь нь бүрэн хэрэгжсэн, 11 тогтоол буюу 26.8 хувь нь хэрэгжих шатанд байна.

3.Хэрэгжүүлэх үйл ажиллагаа удаашралтай байгаагаас “Орон нутгийн өмчтэй аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрыг татан буулгах тухай” 20 дугаар, “Газар нутгийг тусгай хэрэгцээнд авах тухай” 33 дугаар тогтоолын хэрэгжилт хангалтгүй байна.

4.Хугацааны төгсгөлд батлагдсан, хэрэгжүүлж эхлэх хугацаа хүлээгдэж байгаа зэрэг шалтгааны улмаас 8 тогтоолын хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй байна.

## ЗӨВЛӨМЖ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 3 дугаар улирлын байдлаар гарсан аймгийн Засаг дарга, түүний Тамгын газарт даалгасан заалт бүхий тогтоолын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

### Нэг. Төрийн захиргааны удирдлагын хэлтэст:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолын хэрэгжилтийг нэгтгэхдээ хэлтсүүдээс ирүүлсэн биелэлтийг тогтоолын заалт бүртэй тулган няталж, гүйцэтгэлийн үр дүнд дүн шинжилгээ хийж, хэрэгжилтийг чанартай тайлагнахад анхаарч ажиллах;

### Хоёр. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэст:

1.”Хэрэгжилт хангалтгүй” үнэлэгдсэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны “Орон нутгийн өмчтэй аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрыг татан буулгах тухай” аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 20 дугаар

тогтоол, "Газар нутгийг тусгай хэрэгцээнд авах тухай" 33 дугаар тогтоолуудын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч, удирдлага арга зүйгээр хангаж ажиллах;

2."Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй" үнэлэгдсэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны "Аймгийн хөгжлийн 2024 оны жилийн төлөвлөгөө батлах тухай" 42 дугаар, "Багийн нэр тогтоох тухай" 43 дугаар, "Иргэнд 2024 онд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтын санал батлах тухай" 44 дүгээр, "Зарим газрыг тусгай хэрэгцээнд авах тухай" 46 дугаар, "Үнэ бууруулж дахин дуудлагын худалдаа зохион байгуулах тухай" 57 дугаар тогтоолуудын хэрэгжилтийг хангуюулж ажиллах;

#### **Гурав. Нийгмийн бодлогын хэлтэст:**

1."Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй" үнэлэгдсэн "Нэрэмжит болох тухай" аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 50, 51 дүгээр тогтоолуудын хэрэгжилтийг хангуюулж ажиллах;

#### **Дөрөв. Санхүү, төрийн сангийн хэлтэст:**

1."Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй" үнэлэгдсэн "Аймгийн 2023 оны төсвийг тодотгон батлах тухай" аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 41 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах;

#### **Тав. Орон нутгийн өмчийн газарт:**

1."Хэрэгжилт хангалтгүй" үнэлэгдсэн "Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрыг татан буулгах тухай" аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 20 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч, удирдлага арга зүйгээр хангаж ажиллах;

2."Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй" үнэлэгдсэн "Үнэ бууруулж дахин дуудлагын худалдаа зохион байгуулах тухай" аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 57 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах;

#### **Зургаа. Байгаль орчин, аялал жуулчлалын газарт:**

1."Хэрэгжилт хангалтгүй" үнэлэгдсэн "Газар нутгийг тусгай хэрэгцээнд авах тухай" аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 33 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч, удирдлага арга зүйгээр хангаж ажиллах;

2."Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй" үнэлэгдсэн "Зарим газрыг тусгай хэрэгцээнд авах тухай" аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 46 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах;

#### **Долоо. Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт:**

1."Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй" үнэлэгдсэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны "Багийн нэр тогтоох тухай" 43 дугаар, "Иргэнд 2024 онд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил, зориулалтын санал батлах тухай" 44 дүгээр тогтоолуудын хэрэгжилтийг хангаж ажиллах;

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

